

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Галсандаш	Дугаар	L241
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Гурвантэс сум
Төрсөн газар	Гурвантэс сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Овоотын хийд, Ганзагатын хийд, Суварганы хурал	Сүм хийдийн дугаар	ӨГГТ 012, ӨГНН 013, ӨГГТ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Овоотын хийд, Суваргын хурал, Ноён сумын Ганзагатын хурал

Гантулга: За Галсандаш гуай та ямар хийдэд шавилан сууж байсан бэ?

Галсандаш :Би Овоотын хийдэд сууж байсан

Гантулга: Дан Овоотын хийд дээр л сууж байсан уу?

Галсандаш: Тэгсэн.

Гантулга: Өшөө энэ ойр хавийн хийд дээр шавилан сууж байсан?

Галсандаш: Үгүй , суугаагүй.

Гантулга: Та хэдэн оноос хэдэн оны хооронд шавилан сууж байсан, анх хурлаас хэдэн настайдаа хар болсон?

Галсандаш: Хуралд зургаан настайдаа эхэлж суугаад...

Гантулга: Тэгээд хэдэн жил хуралд суугаад хэдтэйдээ хурлаас гарсан бэ?

Галсандаш:Хурал нүүгээд явахаар л ...

Гантулга: Аан, оноор нь яривал?

Галсандаш: Оноор нь яривал , хэдэн он юм бэ дээ...

Гантулга: Хэдэн настай байсан бэ? Хурал нүүгээд явахад та хэдтэй байсан юм?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Хурал нүүгээд явахад...Хорин найман жил л суусан юм байгаа юм. Хорин найм биш арван найман жил суусан юм. Зургаан наснаас эхлээд...

Гантулга: Та хорин дөрөв , таватайл байсан байх нь уу, тэгэхээр?

Галсандаш: Тэгсэн байх.

Гантулга: За за. Танай энэ Овоотын хийдийн чинь нэрийг юу гэж нэрлэдэг байсан юм? Овоотын хийд л гэх үү?

Галсандаш: Овоотын хийд л гэдэг байсан.

Гантулга: Өшөөгөөр нэрлэхгүй юу?

Галсандаш: Үгүй.

Гантулга: Хэзээ хэн байгуулсан хийд вэ?

Галсандаш: Тэрнийг би мэдэхгүй. Хэдэн онд байгуулагдсаныг нь би мэдэхгүй.

Гантулга: Тийм, хэдэн онд хэн байгуулсан талаар мэдэхгүй юу?

Галсандаш: Мэдэхгүй.

Гантулга: Одоо энэ хуучин аймаг хошуу засаг захиргааных нь юугаар яривал Түшээт хандаа орж байна уу, Сайн ноён хандаа орж байна уу?

Галсандаш: Манай Балдан Засгийн хошуу.

Гантулга: Балдан Засгийн хошуу, аль аймгийн? Сайн Ноён хангийнх уу, Түшээт хангийнх уу?

Галсандаш: Түшээт хангийнх байх.

Гантулга: Түшээт хан аймгийн Балдан Засгийн хошуу гэж явж байсан уу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Энэ Овоотын хийдийн ойр орчимд байгаа газар усны нэрийг нэрлэвэл? Өмнөө тийм уултай, ардаа тийм устай гэдэг юмуу? нэр усаар нь нэрлэвэл?

Галсандаш: Нэр усаар , Овоотын уу...

Гантулга: Тийм, газрын нэрийг нь нэрлэвэл?

Галсандаш: Газрын нэрүүд үү?

Гантулга: Тийм.

Галсандаш: Газрын нэрүүд бол цаашаа Сухайт, Хунт., Сугант...Сугант гэж энэ баруун талаар байна, Овоотоод...

Гантулга: Сугайт аа?

Галсандаш: Тийм, Сухайт гэж нэг задгай устай. Сухайт гэж зүүнтээ нь байна. Тэгээд Хотод, Хулстай , Билүүт гээд л дандаа...

Гантулга: Эд нар нь араар нь уу?

Галсандаш: Тийм, цаашаа хонхор замаар.Хуучин Овоотоос зүүн тийш.

Гантулга: Аа мөн мөн.

Галсандаш: Тэгээд дандаа задгай устай газар.

Гантулга: Дандаа задгай устай тийм газрууд байдаг юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Тэгээд л баруун тийшээ Хунт, Нарийн Сухайт, Хошуут, Хөвд...Тэгээд л цаашаа...яваад байна даа. Олон задгай үс бий.

Гантулга: Хуучин харъяаллаар бол Балдан засгийн хошуу гэж явдаг байсан юм байна , тиймээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Ер нь тийм тэгш талархуу газар байсан уу, жоохон энэ уул овооны өвөр дээр байна уу? Хийд маань?

Галсандаш: Энэ яг урдаа гүвээтэй.

Гантулга: Урдаа юу?

Галсандаш: Яг энэ зам дээр. Тэгээд хойшоо бол уул хадтай.

Гантулга: Араараа юу?

Галсандаш: Тийм, тэгээд хойшоо бол тал болж ирээд уултай, хадтай.

Гантулга: Яг хийд бол тэгш тал дээр байгаа юм уу, тиймээ?

Галсандаш: Тийм, тэгш тал дээр.

Гантулга: Эргэн тойрон бол тэгш талбай байгаа юм уу, тиймээ?

Галсандаш: Тийм, урагшаа ар гүвээтэй.

Гантулга: Аан , урд талаараа?

Галсандаш: Тойроод, дэрс задгай гол түнх ...Тийм юман дотор байгаа юм.

Гантулга: Энэ хийдийн ойролцоо эргэн тойрон тахилгатай рашаан ус хад овоо , тийм газар байна уу? Байвал нэр усаар нь хэлээч, энэ зүгт нь тийм юм байгаа гээд?

Галсандаш: Аа тэр зүүн хойд зүгт нь нэг рашаан бий.

Гантулга: Ямар нэртэй рашаан бэ?

Галсандаш: Юуны рашаан гэдэг билээ хө,/ цаанаас нь нэг хүн Салхит гэж хэлтэл/ Аа тийм. Салхитын рашаан. Зүүн хойно нь , энэ Овоотын хийдээс зүүн хойно нь.Уулын энгэрт. Тийм, Эрдэнэ уул гэдгийн энгэрт Салхитын рашаан гэж...

Гантулга: Аа мөн .Тахилгатай рашаан уу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Яаж тахидаг байсан талаар нь ? Жоохон дэлгэрүүлвэл?

Галсандаш: Өө тахидаггүй рашаан.Тахидаггүй байсан.

Гантулга: Хад овоо, уул овоо байна уу, тахилгатай?

Галсандаш:Уул овоо тахихгүй ээ.

Гантулга: Тахихгүй юу, тахидаггүй байсан юм уу?

Галсандаш: Тахидаггүй байсан юм.

Гантулга: Энэ хийдээс хааш хаашаагаа ер нь хорь гучин км байдаг сүм хийд суваргын талаар яривал?

Галсандаш: Ойр одоо энэ Цагаан Суварга л байна.

Гантулга: Цагаан суварга, тиймээ өөр?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Зүүн тийшээ Ганзагатын хийд...

Гантулга: Зүүн тийшээ Ганзагат, баруун тийшээгээ Цагаан суварга уу?

Галсандаш: Тийм, Цагаан суварга .

Гантулга: Өмнөө, урагшаа наашаа юмуу энэ араар?

Галсандаш: Хойшоо байхгүй.

Гантулга: Хойшоо байхгүй , урагшаа ч байхгүй юу?

Галсандаш: Урагшаа байхгүй, тэгээд л хил хязгаар болоод л ...

Гантулга: Энэ Цагаан Суваргын талаар товч ярьж өгөхгүй юу та, хэзээ байгуулсан юм?

Галсандаш: Тэрнийг байгуулсан түүхийг нь мэдэхгүй.

Гантулга: Ямар хүн байгуулсан юм, энэ талаар?

Галсандаш: Цагаан Суваргыг...Бужиг лам гэж нэг тийм суварганы лам байдаг юм , хэлцээтэй...

Гантулга: Хэлцээтэй?

Галсандаш: Хэлцээтэй тийм явган гүйж байдаг лам байсан юм .Тэр л ноёрхож байсан. Өмнө нь Гэндэнцамба гэж нэг лам байсан.

Гантулга: Гэндэн...?

Галсандаш: Гэндэнцамба гэж лам байсан.

Гантулга: Цамба юм уу?

Галсандаш: Лам аа лам.

Гантулга: Үгүй ээ самбуу юм уу, цамба юм уу?

Галсандаш: Цамба.

Гантулга: Энэ нь ямар лам юм , ямар тушаал хэргэмтэй байсан юм?

Галсандаш: Тэр бол ямар ч хэргэм байхгүй ээ.

Гантулга: Энэ Цагаа Суваргын хийд чинь их олон жижиг агуйтай байсан. Энэ нянз мянз хийдэг байсан агуй юу, үгүй юу?

Галсандаш: Үгүй ээ тэр агуй...Тэр дуган сүмийг нь тэр Арьяабал гэдэг том агуйд л хурал хурдаг.

Гантулга: Тэр хойд талд байгаа том агуй мөн үү?

Галсандаш: Тийм, тэр хойд талд байгаа урагшаа харсан.

Гантулга: Арьяабалын агуй гэдэг юм уу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Дотроо Арьяабал залаатай?

Галсандаш: Тийм.

Гантулга: Хэдэн лам хурдаг байсан бэ?

Галсандаш: Өө тэр цөөхөн байсан байх аа даа.Арав хориод л байсан байх.Тэрнээс илүүгүй. Зай нь тааруухан байгаа биз дээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Зай нь тааруухан гэхдээ тэр байшин савынх нь суурь нилээн, бас нэг том суварга байна лээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Суварга нурчихсан. Тэр суваргаар нь нэрлэсэн юм уу даа , тиймээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Том Цагаан суварга байна лээ ?

Галсандаш: Тийм, тэр суваргаар нь нэрлэсэн юм.

Гантулга: Өшөө юу байсан тэрэн дээр, тэр Аръяабалын агуйгаас өмнө? Суварга?

Галсандаш: Суварга , тэгээд л өөр дуган муган байгаагүй.

Гантулга: Аа мөн .Өөр дуган дацан ерөөсөө байгаагүй?

Галсандаш: Байгаагүй. Аръяабал гэдэг тэр агуйд л хурлаа хурдаг байсан.

Гантулга: Өө зөв зөв. Тэгээд байнга хурах уу, үе үе хурах уу?

Галсандаш: Үе үе хурна. Цагийн хурал гээд үе үе хурна.

Гантулга: Энэ Манзширын л ном уншаад байх уу?

Галсандаш: Тийм. Цагийн хуралтай л газар байсан.

Гантулга: Тэр ноёлж байсан лам нь хэн гэл ээ?

Галсандаш: Пунцаг гэлэн.

Гантулга: Пунцаг гэлэн. Гэлэн хүн байсан юм уу?

Галсандаш: Тиймээ тийм.

Гантулга: Хурал ном нь ямар хурал уншдаг байсан юм бол , тэр талаар ?

Галсандаш: Тэр талаар би сайн мэдэхгүй. Тэнд хурдаггүй, тэр болгон очдоггүй байсан юм.

Гантулга: Нүгнээ энэ тэр тахидаг байсан юм болов уу?

Галсандаш: Яадаг байсан юм , мэдэхгүй. Нүгнээ тахиж байсан юм уу үгүй юмуу.Би чинь Овоотод л байж байгаад , тэр Суваргаар ч нэг их очдоггүй байсан. Тэндхийн лам нар тэгээд яасан, бас л энэ хэлмэгдүүлэлтийн үед алга болсон уу?

Галсандаш: Тэгсэн байх.

Гантулга: Баригдаж тавигдсан уу, эсвэл тэр талаар дуулсан уу, та?

Галсандаш: Дуулаагүй. Овоотынх л их явснаас, Суварганыхаас ер нь яваагүй байх аа?

Гантулга: Шарын шашны хийд байсан уу, тэр бол?

Галсандаш: Тэгэлгүй.

Гантулга: Том том лам нар хутагт хувилгаан гэж бол тэнд байхгүй юу?

Галсандаш: Байхгүй.

Гантулга: За за. Энэ Ганзагатын хийдийн талаар?

Галсандаш: За Жамба ловон гэж байсан, Давга унзад гэж байсан.

Гантулга: Жамба ловон , өөр?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Давга унзад.

Гантулга: Хэн гэнэ ээ?

Галсандаш: Давга унзад...Жагдал гэлэн гэж байсан.

Гантулга: Жагдал гэлэн гэсэн үү?

Галсандаш: Тийм, Жагдал гэлэн.

Гантулга: Энэ Ганзагатын хийдийн хэзээ байгуулсан , хэн байгуулсан талаар мэдэхгүй юу?

Галсандаш: Мэдэхгүй ээ.

Гантулга: Энэ ер нь хэр том хурал байсан бэ?

Галсандаш :Жижигхэн.

Гантулга: Жижигхэн үү, хэдэн ламтай ?

Галсандаш: Бас л энэ Цагаан суварга шиг л юм.

Гантулга: Цөөхөн ламтай?

Галсандаш: Өө цөөхөн ламтай.

Гантулга: Хэдий орчим ламтай вэ?

Галсандаш: Бас арав орчим л...

Гантулга: Байнгын хуралгүй юу?

Галсандаш: Тийм, жижиг хурлууд байсан юм аа.

Гантулга: Сүүлд байгуулагдсан байна уу ,тиймээ?

Галсандаш: Тийм байлгүй.

Гантулга: Бас л шарын шашны хийд үү?

Галсандаш: Тэгэлгүй яахав.

Гантулга: Сор залах ч байдаг юм уу, тийм юмнууд хийж байсныг нь дуулаагүй юу?

Галсандаш: Үгүй байх аа.

Гантулга: Майдар эргэх, ганжуур эргэх энэ тэр тэр талаар юм байгаагүй юу?

Галсандаш: Үгүй, тийм юм байгаагүй.

Гантулга: Тэр хавьд нь бас тэр хурлаас нь тахидаг газар гэж байсан болов уу?

Галсандаш: Ганзагат чухам ямар байсан юм , энэ Цагаан Суваргат бол тэр майдар эргэж , сор мор залж байгаагүй.

Гантулга: Байгаагүй юу?

Галсандаш: Байгаагүй.Энэ Ганзагат чухам мэдэхгүй юм.

Гантулга: Тэр араараа их том хадтай уул байна лээ ш дээ, тэрийг нь юу гэж нэрлэдэг юм?

Галсандаш: Алины?

Гантулга: Тэр Цагаан суваргын.

Галсандаш: Аа тэрнийг чинь...ямар уул...Уул худгийн хяр гэж.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Уул худгийн хяр аа, энэ эргэн тойронд нь тахилгатай уул ус байна уу, тэр Суваргын? Тэндээсээ тахидаг байсан рашаан ус, хад овоо?

Галсандаш: Хуршуудын тэнд нэг, цаана Хуршууд гэж нэг гол бий, Суваргын . Дээр Хуршуудын тахилга гэж...Тэрнийг тахидаг, тахидаг нэг уул бий.

Гантулга: За өмнөө, зүүн баруугаар нь ?

Галсандаш: Зүүн баруун талаар нь өөр байхгүй ээ.Тэр Хуршуудын тахилга гэж нэг шовхоо уул бий.Тэрнийг л тахидаг юм.

Гантулга: Энэ Ганзагатын хийдийн ойр орчимд тахидаг рашаан ус, хад овоо? Уул ус байсан уу?

Галсандаш: Байхгүй байх аа.

Гантулга: Байгаагүй юу, тэрийг бол та сайн мэдэхгүй юм байна?

Галсандаш: Сайн мэдэхгүй.

Гантулга: Энэ Овоотын хийдийн ерөнхий зураг бий ш дээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Одоо ингээд нэртэй зураачид юмуу, уран улсууд хийдийн ерөнхий байдлыг зурчихдаг ш дээ, ингээд дуган сүмийг нь оруулаад лам нарын хашаа хороог оруулаад тийм хийдийн тойм зураг бий юу?

Галсандаш: Тийм зураг байхгүй ээ.

Гантулга: Зурсан ч байдаг юм уу...?

Галсандаш:Үгүй ээ юу гэж байхав , тийм юм байхгүй.

Гантулга: Шарын гэлүгвагийн хурал байсан уу?

Галсандаш: Тэгсэн. Гэлүгвагийн?

Гантулга: Тийм Шарын шашны хурал байсан уу л гэсэн үг?

Галсандаш: Тэгсэн.

Гантулга: Гол шүтээн нь ямар шүтээнтэй байсан юм, ядам нь , сахиус нь ?

Галсандаш: Майдар бурхан.

Гантулга: Майдар, өөр?

Галсандаш: Тэгээд сахиус...

Гантулга: Янсан ядам гэсэн тиймээ?

Галсандаш: Тийм, Янсан ядам.

Гантулга: Өшөө одоо гол шүтээн, нандин шүтээн бурхан? Овоотын одоо тэр бурхан чинь тийм шүү гээд одоо нэртэй тийм юм байна уу?

Галсандаш: Өө байлгүй дээ, тэр би одоо сайн мэдэхгүй л байна.

Гантулга: Одоо сайн санахгүй байна уу?

Галсандаш: Санахгүй байна. Байлгүй яхав.

Гантулга: Энэ Овоотын хурал дээр нийтдээ хичнээн лам хувраг хурж байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: За нэг 500-аад байсан байх.

Гантулга: 500-аад уу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Байнгын суудаг нь хэд байсан бэ?

Галсандаш: Байнгын суудаг нь таван зуу арай хүрэхгүй байсан байх.

Гантулга: Аа ирж очдог байсантайгаа нийлээд л таван зуу юу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Таван зуугаас чинь ирж очдог байсан улсууд нь аль аль хошуу нутгийх байсан бэ?

Галсандаш: Өө энэ ойр зуурынх.

Гантулга: Аа энэ Балдан засгийн хошуунаас уу?

Галсандаш: Тийм. Тэгээд л энэ Байшинтын хурал , Чойроос ч гэлээ ирнэ л дээ.

Гантулга: Аа бас ирэх үү?

Галсандаш: Тийм ,гэхдээ түвт ч ирээд байхгүй.

Гантулга: Чойр гэдэг нь эн Баруун ,Зүүн Чойр уу?

Галсандаш: Үгүй одоо Чойрын хийд л гээд ...Өлгий хийд .

Гантулга: Өлгий хийд , аа мөн мөн?

Галсандаш: Тийм, тэндээс бас ирдэг байсан юм.Хааяадаа ирнэ шүү гэхдээ, түвт ирээд байхгүй. Тэгээд л Байшинтын хурлаас ирж лам нар хурна.

Гантулга: Энэ Овоотын хийдийн хутагт хувилгаан юм уу, энэ орон хийдийн эзэн нь ямар хүн байсан бэ?

Галсандаш: Хутагт хувилгаан уу?

Гантулга: Тийм, одоо орон хийдийнх нь тэргүүн лам нь хэн байсан бэ? Хутагт хувилгаан байсан уу, зүгээр эрдэмтэй лам , цол мяндагтай лам нар гавж цорж гээд?

Галсандаш: Энд одоо хутагт хувилган гэхээр...Жасрай гэгээн. Эндхийн унаган хүн.

Гантулга: Жасрай гэгээн Дашням гэдэг үү?

Галсандаш: Тийм, Дашням.

Гантулга: Жасрай гэгээний хувилгаан Дашням гэдэг лам байсан юм уу?

Галсандаш: Тийм .

Гантулга: Тэр хүний талаар та өчигдөр нэг дурсаж байсан , тэр хүнийхээ тухай нэг яриач. Танай зиндаа байсан, баригдаж тавигдаж байсан талаар та нэг дурсаж байсан даа? Тэр талаар нэг жоохон дэлгэрэнгүй ярихгүй юу?

Галсандаш: Өө тэр номын дамжаа хурж байхад л тэр Шавран ламтныг аваад явчихсан. Тэгэхэд л Дашням хоёул хурж байсан юм.Тэгэхэд номын дамжаагаар шөнө аваад явчихсан юм. Тэгээд тэр Шавран ламтан хайлж байсан.

Хогийн нохой болж төрсөн бол гэж хайлж байсан.

Гантулга: Хогийн нохой болж төрсөн...?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Хогийн нохой болж төрсөн бол гээд хайлж байсан. Тэгээд аваад явчихсан, бид нар ч айлтгаад байсан.

Гантулга: Шавран лам, Дашням Жасрай гэгээн та нар нэг зиндаа байсан юм уу?

Галсандаш: Зиндааны хуралд л ирж хүрж байсан юм.

Гантулга: Өмнөө одоо том алдартай эрдэмтэй лам нар байсан уу?

Галсандаш: Байлгүй дээ.

Гантулга: Захаас нь нэрлэвэл?

Галсандаш: Тэр Бямба ловон байсан, Балтав ловон байсан.

Гантулга: Дандаа энэ Овоотын хийд дээр сууж байсан уу?

Галсандаш: Тийм, дандаа Овоот дээр суудаг.

Гантулга: Жамба ловон?

Галсандаш: Жамба ловон ч одоо Ганзагат дээр ч очдог, Овоот дээр ч очдог...Хоёр тийшээ хурдаг...

Гантулга: Өөр?

Галсандаш: Өөр Цогвандан гэж байсан.

Гантулга: Хэн гэнэ ээ?

Галсандаш: Цогвандан.

Гантулга: Энэ сайн гэвш хүн үү?

Галсандаш: Өө тэр ловон хүн.

Гантулга: Өмнөө?

Галсандаш: Сономшарав гэж хүн байсан.

Гантулга: Энэ ямар хүн бэ?

Галсандаш: Өө бас л цорж хүн байсан.

Гантулга: Өөр?

Галсандаш: За өөр ч хүн байгаагүй шүү.

Гантулга: Том зурхайч эмч улсууд гэвэл?

Галсандаш: Эмч...Цогвандан эмч байсан, Балтав гуай эмч байсан.

Гантулга: Жамба ловон?

Галсандаш: Жамба ловон ч эм барьдаггүй байсан юм аа.

Гантулга: Зурхай, Чойрын хүн үү?

Галсандаш: Зурхай...Чойрын л хүн.

Гантулга: Сономшарав нь?

Галсандаш: Сономшарав нь цогчины хүн. Аль аль нь Чойрын л хүн.

Гантулга: Өөр одоо ом унзад ч гэдэг юм уу, гэсгүй хүмүүс?

Галсандаш: Манай эцэг зурхайч, шар зурхайч хүн байсан. Дамбийжанцан гээд.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Зурхайч хүн байсан уу?

Галсандаш: Тэгсэн.Цогчинд...

Гантулга: Таны ах нар олон лам хүн байсан гэж та ярьж байсан?

Галсандаш: Манай ах бас л ловон хүн байсан. Шарав гэж. Жа Шарав гэж

Гантулга: Том ах чинь үү?

Галсадаш: Тийм.Гэсгүй ч хийж байсан, ловон ч хийж байсан.

Гантулга: Унзад юу байсан гэнэ ээ, гэсгүй хийж байсан?

Галсандаш: Тийм.

Гантулга: Унзад нь хэн гэж хүн байсан гэл ээ?

Галсандаш: Унзад ч манай эцэг л байсан. Манай нэг ах гэсгүй байсан.

Гантулга: Гэсгүй хийж байсан. Хэн гэж хүн байсан гэнэ ээ?

Галсандаш: Шаравын Дорж.

Гантулга: Аан ахаараа овоглодог?

Галсандаш: Тийм.

Гантулга: Юу юу? Та тэр ахынхаа тухай баригдаад явахдаа уян дээрээ хөөргөө үлдээчихсэн энэ тэр гээд дурсаж байсан тэр дурсамжаа яриач?

Галсандаш: За тэгвэл Баруун гол гэдгээс баригдаад тэгээд замдаа Янжингийн гэдэг айлын гадаа хөөрөг даалингаа орхиод гэр дээр нь хулсан үрт тэнзэн ташуураа орхиод тэгээд явж байсан. Осор гэлэн гэдгэс баригдаад, Осор гэлэн хоёулангийн нь барьж аваад тэгээд Сүндуй гэдэг хүн, Сүндуй гэдэг дарга та хоёр юу төлөвлөж байгаав гэж айлгаж сүрдүүлж тэгж барьж аваад тэр хоёрыг.Тэгээд явж байсан юм. Тэгээд явж , долдугаар отряд руу явуулчихаад.Нөгөө хоёр ламыг, тэгчихээд...Манайх баруун хойд талаар энгэрт байсан.Тэгээд тэнд Батаа, Сүндуй хоёр хүрч ирж юм бичүүлээд. Хөрөнгө мал бичүүлж аваад тэгээд, хөрөнгө бүртгүүлчихээд тэгээд явчихаж байсан юм.

Гантулга: Төвд лам нар гэж байсан уу, энэ хурал дээр?

Галсандаш: Төвдөөс ирсэн лам нар гэж дуулдаагүй.

Гантулга: Ирж одоо тэр дацангуудад хичээл заадаг ном заадаг байсан улс гэж байгаагүй юу?Хүрээ энэ тэрээс, Богдын хүрээнээс ч юмуу?

Галсандаш: Аа тийм лам байсан. Сарт хошууны Сандан гэж тимий Чойрын лам ирж Чойрын ном зааж байсан.

Гантулга: Сарт хошуу?

Галсандаш: Тийм, Сарт хошуу.

Гантулга: Сандан гэл үү, Чойрын ном заадаг байсан юм үү?

Галсандаш: Тийм, Чойрын ном заадаг байсан. Миний багш байсан.

Гантулга: зурхай, эмнэлэг, Жүдийн багш гэж энэ тэндээс ирсэн улсууд?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Тэр Хувиран багш гэж нэг том багш байсан юм. Лам байсан юм , энэ Овоотод. Хувиран багш. Тэр харин том хүн байсан даа. Тийм хамгийн том нь л тэр байсан юм.

Гантулга: Хэн гэж хүн байсан бэ, нэр нь ?

Галсандаш: Хувиран багш, тэр чинь одоо нэр нь хэн гэж хүн байсан...

Гантулга: Хаанахын хүн юм ?

Галсандаш:Манай эндхийн л хүн байсан.

Галсандаш: Нэрийг нь хэн гэж байлаа...Самдан багш л гэж байсан юм.

Гантулга: Зоч одоо тийм улсууд байсан уу, зоч лүйжин тавьдаг? Лүйжин тавьдаг улсууд байсан уу?

Галсандаш: Байсан юм гэсэн.За байз, хэн гэж байлаа...Даш лооен.

Гантулга: Лооен?

Галсандаш: Тийм, Даш лооен. Энэ нэг сүйдтэй хүн байсан . Манай урдах нь талд байсан юм.

Гантулга: Энэ Овоотын хийд дээр сууж байсан уу?

Галсандаш: Тэр энэ Овоотын хийд дээр байсан юм, Дашлооен. Тэр ч сайн хүн байсан юм гэсэн.

Гантулга: Тэр хүний талаар сонсч байсан түүх домогны юм гэвэл ?

Галсандаш: Домогны юм алга.

Гантулга: Тэр Жасрай гэгээн, Шавран ламын талаар та дэлгэрүүлж ярихгүй юу, ямар хэдэн үе тодорсон юм , хутагт хувилгааны. Ямаршуу улс байсан таныг бага байхад. Үеийн л улс байсан байх даа?

Галсандаш: За тэр надаас ч бага байсан . Жасрай гэгээн надаас бага. Одоо тэний энэ хойд дүр чинь одоо Өвөрмонголд байна ш дээ. Хэн гэхивэ...

Гантулга: Шавран лам?

Галсандаш: Шавран ламын хойд дүрийг би дуулаагүй.

Гантулга: Үгүй ер нь Шавран лам ямаршуу хүн байсан ?

Галсандаш: Мэдэхгүй. Даян гэгээн гэж л их ид шидтэй хүн байсан юм.

Гантулга: Бас энд ирдэг байсан юм уу?

Галсандаш: Үгүй ээ, энэ орон шоронд л бас энэ хэлмэгдэлтээр барьж аваад л шоронд хийчихсэн .Хаана л бол Даян гэгээн явж байдаг. Тэгээд өнөөхийг нь бүртгэх гээд л тэгээд шоронд байснаа гаргачихсан юм. Шоронд бариад л хийчихдэг, тэгээд гадуур нэл л явж байдаг. Тийм хүн байсан юм, Даян гэгээн. Тийм л ид шидтй хувилгаан байж шүү.

Гантулга: Тэр Даян гэгээний хойд дүр байсан юм уу?

Галсандаш: Үгүй ээ, Даян гэгээн чинь тусгай.Одоо энэ Жасрай гэгээнийг чинь орон шоронд оруулж, цэрэгт явуулж тэгээд дийлээгүй юм гэсэн.Бугаа овоолсонгүй гэж цэрэгт байхад, тэр сэнжтэй аяганд ус хийгээд угааж угааж буруу нь харуулаад тавьчихдаг байсан. Тэгж хэлдэг байсан , Жасрай гэгээнийг.

Гантулга: Энэ Овоотын хурал дээр чинь гэлэн сахилтай хүн олон байсан уу?

Галсандаш: Өө зөндөө бий.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Багцаалдвал?

Галсандаш: Өө мэдэхгүй, ер нь нэлээн л олон бий.

Гантулга: Нэлээн олон уу, зуу?

Галсандаш: Зуугаад байсан байлгүй яахав.

Гантулга: Нэртэй гэлэнгээс нь хэлвэл , тэр Жамба ?

Галсандаш: Жамба ловон.

Гантулга: Жамба ловон чинь гэлэн байгаагүй юу?

Галсандаш: Гэлэн байлгүй яахав , гэлэн байсан.

Гантулга: Өмнөө?

Галсандаш: Өө зөндөө зөндөө.

Гантулга: Сайн уран одоо зураач нар байсан уу?Овоотын хурал дээр?

Галсандаш: Байсан.

Гантулга: Хэн хэн гэж байсан, хэргэм зэрэг гэж байх уу тэдэнд бол? Тэр уран улсуудад, зураачуудад?

Галсандаш: Байхгүй ээ.

Гантулга: Одоо Чойроос гээш мэвш гэдэг шиг?

Галсандаш: Байхгүй ээ.

Гантулга: Жишээлбэл хэн гэдэг хүн байсан бэ?

Галсандаш: Гэндэнсамба гээд л зураач байсан юм.

Гантулга: Гэндэнсамба аа, бурхан зурдаг хүн байсан уу?

Галсандаш: Дан бурхан зурдаг, янз бүр л байсан.

Гантулга: Хэн гэнэ ээ?

Галсандаш: Гэндэнсамба...Дэгнүү гээд бас байсан.

Гантулга: Хэн гэнэ ээ?

Галсандаш: Дэгнүү.

Гантулга: Олон зурхайч байсан уу?

Галсандаш: Тэгсэн.Зурхайч олонтой байлгүй.

Гантулга: Ер нь зурхайч элбэг байсан уу?

Галсандаш: Өө байсан.

Гантулга: Эмч нар?

Галсандаш: Зөндөө.

Гантулга: Нэрлэвэл?

Галсандаш: Тэгээд л Балтав ловон, Жигмэд гэлэн тэгээд л энэ Цогвандан... зөндөө.

Гантулга: Энэ Овоотын хийд дээр ер нь хамба лам гэж байсан уу?

Галсандаш: Хамба лам уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Аан хийдийн хамба гэж байсан уу, зүгээр хийд дотроосоо хийдийн тэргүүн лам?

Галсандаш: Хамба лам чинь л тэр ловон эд нар.

Гантулга: Хамба ловон л хамба лам? Шуналай лам гээд та ярьж байсан даа?

Галсандаш: Тэр чинь хамба лам.

Гантулга: Шуналай лам л гэж байсан уу? Цорж?

Галсандаш: Цорж байна аа, байна. Цорж байлгүй.

Гантулга: Жишээлэхэд?

Галсандаш: Тэр ловонгууд чинь заримдаа цорж болчихсон л байдаг юм.

Гантулга: Даа лам , нярав?

Галсандаш: Байлгүй.

Гантулга: Даамал?

Галсандаш: Байна аа, жасын нярав, даамал.

Галсандаш: Хүмүүсийнх нь нэрийг нэрлэвэл? Ганц нэгээс нь?

Галсандаш: Жамбал нярав , Дорж нярав, Жавз нярав гээд нярвууд байна аа. Даамлууд ч олон байсан. Дуганч нар гэж бас байна.

Гантулга: Одоо энэ Овоотын хийд дээр байгаа сүм дуган дацангуудыг нэрлэвэл хичнээн барилга байшин байна?

Галсандаш: Суваргуудыг нь л мэднэ.

Гантулга: Хичнээн дуган , хичнээн суварга байсан бэ?

Галсандаш: Ганц суварга, дөрвөн дуган байсан.

Гантулга: Дацан?

Галсандаш: Өө дацан...Чойр дацан тэгээд ямар ямар ч дацан, ядам сахиус янз бүрийн л юм...

Гантулга: Дацан сургууль нь энэ дуган дотроо хичээллэдэг байсан уу, эсвэл ийм тусдаа дацан сүмтэй байсан уу?

Галсандаш: Ямар ий?

Гантулга: Энэ Чойр , Мамба эд нар тус тусдаа дугантай байсан юм уу, нэг дугандаа л хурдаг байсан юм уу?

Галсандаш: Нэг дугандаа хурна.

Гантулга: Аа нэг дуган, цогчин дугандаа л хурах уу?

Галсандаш: Цогчиндоо л хурна.

Гантулга: Ядмын дуган гэж байсан гэсэн тиймээ?

Галсандаш: Тийм. Сахиусны дуган. Дүйнхорын дуган...дөрвөн дуган л байсан. Тэрний чинь туурийг л би одоо олж өгөх гээд байгаа юм . Ганцхан дуган...

Гантулга: Ядмын дуган...?

Галсандаш: Тийм, цогчин дуган.

Гантулга: Дүйнхорын дуган...?

Галсандаш: Сахиусны дуган.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Дүйнхорын дуган гэж байсан уу?

Галсандаш: Дүйнхорын дуган байна аа.

Гантулга: Аа ингээд дөрвөн дугантай.Та багш нарынхаа талаар нэг тодруулж ярьж өгөөч?

Галсандаш: Юу гэж...одоо зургаан багш байсан.

Гантулга: Тэр Чойрын ном зааж байсан багшийнхаа тухай?

Галсандаш: Чойрын номыг аграмб багш зааж байсан. Тэр Сарт хошууны Самдан гэдэг багш зааж байсан.Тэгээд тэр Санжшарав гэж багш байсан, доод талын. Хэд болов?

Гантулга: Гурав болж байна.Гурван хүн байна.

Галсандаш: Чойрын багш .Чойрын багш чинь гурван хүн байсан. За тэгээд бусад нь...

Гантулга: Уншлага...?

Галсандаш: Манай эцэг байсан, Дамаа багш гээд байсан. Ингээд хэд болж байна.

Гантулга: Тав болж байна.

Галсандаш: Тав уу, нэг нь ямар багш...Өө Дором багш.Тэр, ингээд зургаан багш болж байна.

Гантулга: Та ямар ном заалгаж байсан бэ, жишээлбэл одоо Чойрын номноосоо ямар ямар ном?

Галсандаш: Өө тэгээд л анхнаасаа хадаг шидав өгж золгож байгаад л тэгээд хадаг шидваас эхэлдэг шүү дээ.Тэгдэг биз дээ.

Гантулга: Тийм тийм.

Галсандаш: Тэрнээс чинь эхэлж золгож байгаад л тэгээд юу ч өгсөн байдаг юм тэгээд...Тэгээд л дууссан байдаг юм.

Гантулга: Энэ хийд дээр ном барладаг юм байсан уу?

Галсандаш: Байлгүй.

Гантулга: Барчингууд энэ тэр гээд?

Галсандаш: Байлгүй яахав.

Гантулга: Тэрийгээ яривал, тэр тухайгаа яривал?

Галсандаш: Үгүй ээ, тэр ном барлаад л харагддаг байсан .

Гантулга: Ямар ямар улсууд?

Галсандаш: Үгүй ээ тэр ном болгоныг л барална./инээв/

Гантулга: Үгүй ээ, тийм барчин энэ тэр гээд, /инээв/ модоор барладаг байсан энэ тэр гээд та жоохон дэлгэрэнгүй ярихгүй юу?

Галсандаш: Модоор л барлана даа. Ганжуур данжуур эд нарыг чинь бичиж барихгүй, дандаа л барална.

Гантулга: Энэ суварга нь ямар суварга байсан бэ, жанчив суварга , бодь суварга ч гэдэг юм уу? Тийм ямар нэгэн нэр байна уу?

Галсандаш: Овоотын уу?

Гантулга: Тийм, Овоотын ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Суварга л гэхээс нэр байхгүй.

Гантулга: Байхгүй юу?

Галсандаш: Байхгүй.

Гантулга: Энэ дуганаас гадна өөр Майдрын сүм ч гэдэг юм уу, Дарь эхийн сүм ч гэдэг юм уу тийм сүм байдаг байсан уу?

Галсандаш: Байгаагүй.

Гантулга: Та нэг Цанжид их хурдаг байсан гэж ярьж байсан ш дээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Тэр талаараа жоохон тодруулж ярьж өгөөч?

Галсандаш: Шөнө болоод л бүрээ гэсгүүр хангинаад л шөнө дундын алдтайд, нэг их хүйтэнд хурдаг хурал байсан юм.

Гантулга: Шөнө, аа өвөл хурдаг байж ?

Галсандаш: Тийм, өвөл яг хүйтнээр . Хэцүү л юм билээ.

Гантулга: Цанжид гэж , хэд хоног хурдаг байсан бэ?

Галсандаш: Ай мэдэхгүй ээ, долоо хоног хурдаг, байл уу, хэд хоног...

Гантулга: Тэгээд их аятай , дантай хурах уу?

Галсандаш: Аа тэгэлгүй.

Гантулга: Санжидмолom.Өөр тэгээд ямар ямар ном хурах уу?

Галсандаш: Өө тэгээд мэдэхгүй, мартчихаж. Ямар ямар хурдаг байсныг нь .

Гантулга: Хийдийн цогчин уншлаганы талаар та жоохон дэлгэрэнгүй ярихгүй юу? Цогчин уншлаганыхаа талаар , эхлээд өглөө босоод яадаг байсан , лам нарынх нь тэр зан үйлийнх нь талаар жоохон дэлгэрэнгүй ярихгүй юу?

Галсандаш: Мартцаан мартчихсан.

Гантулга: Та нэг сайн унзад хүн байсан гээд ярьсан ш дээ?

Галсандаш: Тийм. Манай эцэг үү?

Гантулга: Нэг их сайн хоолойтой хүн байсан гээд?

Галсандаш: Тийм, манай эцэг л цогчин унзад л байсан юм. Тэгээд цогчин унзад суугаад...Намайг л унзадын алба л амархан, хоолой бий бол унзад л болно доо гэж байсан юм.

Гантулга: Цогчин уншлаганд нь ямар ямар ном хурдаг байсан юм ?

Галсандаш: Оо мэдэхгүй. Мэдэхгүй юу байхав, марчихаж.

Гантулга: Сарын хурлууд , шинийн найман ,арван таван гээд?

Галсандаш: Цагаалчихаад л магтаал арван таван хоног хурдаг байсан.

Гантулга: Аан цагаан сарын шинийн нэгэнд?

Галсандаш: Тийм, шинэлчихээд тэгээд тардаг байсан юм.

Гантулга: Битүүний хурал?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Битүүнд лхамялна.

Гантулга: Хорин есөнд?

Галсандаш: Мэдэхгүй ээ, одоо хорин есөнд яадаг юм.

Гантулга: Хорин таванд? Арван хангал уншдаг байсан уу?

Галсандаш: Тэгсэн. Арван хангалыг чинь бүтэн цээжээр гүнрэг уншина. Гүнрэг хурна.

Гантулга: Гүнрэг хэдийд, сар бүрээр хурдаг байсан юм уу?

Галсандаш: Өө байс хийгээд л хурна. Гүнрэгийн багш байсан. Гүнрэгийг заадаг байсан, тэр аграмба багш, тэр Чойрын.

Гантулга: Одоо жилийн тойронгоор нь ярих юм бол жимлд ямар ямар хурал хурах вэ? Одоо Цагаан сараас эхлээд хурвал?

Галсандаш: Одоо Ганзагат чинь гүнрэг хурна. Олон чагжтай, олон янзын чагжтай. Тийм биз?

Гантулга: Тийм, игчатай.

Галсандаш: Цог уншина биз?

Гантулга: Уншина аа./ ярилцлага түр завсарлав/... Цагаан сар?

Галсандаш: Байлгүй.

Гантулга: Өөр?

Галсандаш: Өөр байлгүй, мартчихжээ.

Гантулга: Зулын хорин таван?

Галсандаш: Зулын хорин таван...

Гантулга: Богд ламын дүйчэн өдөр?

Галсандаш: Тийм, сүйд болно.

Гантулга: Хайлан?

Галсандаш: Тийм, хайлан... Дөчин тав хоног Хайланд сууна.

Гантулга: Тэр талаар жоохон дэлгэрүүлээд?

Галсандаш: /инээв/

Гантулга: Цам гардаг басйан уу?

Галсандаш: Цам гарна.

Гантулга: Майдар эргэдэг байсан уу, Майдар хэдийд эргэдэг байсан? Намар уу, хавар уу, зун уу?

Галсандаш: Зун л эргэдэг байсан байх даа.

Гантулга: Цам жилдээ ганц уу, хоёр гурав гардаг эргэдэг байсан уу? Улиралдаа?

Галсандаш: Ганц байх аа ганц.

Гантулга: Тийм дэгийнх, ийм дэгийнх гэдгийг нь та мэдэх үү?

Галсандаш: Мэдэхгүй.

Гантулга: Хүрээ дэг ч гэдэг юмуу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Мэдэхгүй.

Гантулга: Цамын тэр дүр багийн тухай, хохимойгоос гадна?

Галсандаш: Аа тэр хохимой ч гаралгүй.

Гантулга: Өөр? Цагаан өвгөн?

Галсандаш: Өө янз бүр.

Гантулга: Хурал тартлаа цам гарч байсан уу, ер нь ?

Галсандаш: Тэгсэн.

Гантулга: Жилдээ л гарах уу?

Галсандаш: Тэгэлгүй.

Гантулга: Хэдийнээс цамтай болсон юм , танай хурал?

Галсандаш: Ер нь энэ намайг мэдэхийн л .

Гантулга: Майдар эргэдэг байсан уу?

Галсандаш: Эргэлгүй.

Гантулга: Жил бүрийн юу, улиралдаа юу?

Галсандаш: Жил бүр.

Гантулга: Хэдэн өдөр эргэдэг байсан?

Галсандаш: Нэг л өдөр.

Гантулга: Сүсэгтэн их цугладаг байсан уу?

Галсандаш: Зөндөө, тэр ойр хавийн хөдөөний улсууд чинь.

Гантулга: Майдар эргэхэд майдарын цам гэж гарч байсан уу?

Галсандаш: Гарч байсан.

Гантулга: Тэрийг одоо жоохон дэлгэрүүлээд яривал? Та санаж байна уу?

Галсандаш: Санахгүй байна аа, мартчихсан.

Гантулга: Ганжуур эргэдэг байсан уу?

Галсандаш: Эргэнэ ээ.

Гантулга: Яаж эргэдэг байсан, хошууныхаа нутгаар уу, хүрээ хийдээ?

Галсандаш: Хүрээ хийдээ тойрч эргэдэг.

Гантулга: Аан хийдийнхээ...?

Галсандаш: Тийм, хажуугаар нь тэгээд л ганжуур данжуур хийж аваад л эргээд байна.

Гантулга: Хэдүүлээ?

Галсандаш: Өчнөөн олуулаа.

Гантулга: Явган л эргэдэг байсан уу?

Галсандаш: Явган л эргэнэ.

Гантулга: Бүх лам нар уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Хөдөөний улсууд л эргэнэ.

Гантулга: Хэдэн өдөр эргэдэг байсан.

Галсандаш: Тэр хүний санал мэднэ. Өчнөөн хоног эргэнэ гэнэ үү, ганц хоног эргэнэ гэнэ үү, зургаан долоон хоног эргэнэ гэнэ үү тэр хүний сүсэг бишрэл мэднэ.

Гантулга: Ганжуураас өөр Данжуур ч юмуу, өшөө том Жадамба судар ч юмуу том том судар авч эргэдэг байсан уу, хүмүүс?

Галсандаш: Эргэлгүй

Гантулга: Жишээлбэл?

Галсандаш: Ганжуур, Данжуур. Тэгээд л шүтээнүүд. Ер нь хамгийн том шүтээн чинь л ганжуур данжуур. Жадамба гэдэг чинь бага аа ном. Тэгээд л хөдөөний улс л их эргэнэ.

Гантулга: Цагаан сараар чинь одоо цагаан сарын хурал нь битүүнэс урагш хэд хоногийн өмнө эхэлдэг байсан бэ?

Галсандаш: Мэдэхгүй ээ, одоо хэд хоногийн өмнө...

Гантулга: Тэрийгээ юу гэдэг юм, хуучин хурал энэ тэр гэдлэг байсан уу үгүй юу? Сар буух ч гэдэг юм уу, янз янзаар нэрлэдэг байсан?

Галсандаш: Хэн мэдэхэв. Цогчин хурсаар байгаад л тэгээд...

Гантулга: Битүүнийхээ урдаа?

Галсандаш: Тэгээд л цогчин хураад л байдаг.

Гантулга: Тэгээд өглөө нь сор залах уу, шинийн нэгэндээ?

Галсандаш: Битүүнд.

Гантулга: Битүүндээ зална. Тэгээд л ерөөл арван хэдэн хоног уншчихна?

Галсандаш: Тэгнэ. Битүүний орой сор залаад л тэгээд л ...

Гантулга: Бурхан багшийн дүйчэн өдрөөр ямар ном уншдаг байсан юм?

Галсандаш: Тэрнийг юу гэдэг байсан, одоо л ярьж байсан ...

Гантулга: Та тэр сор залахад нэг сайн унзад цамнадаг байсан гэж ярьж байсан ш дээ?

Галсандаш: Тийм.

Гантулга: Тэр талаараа нэг тодруулахгүй юу?

Галсандаш: Сорыг уу?

Гантулга: Тийм, хэн гэдэг хүн билээ, сор хийхдээ яаж хийдэг байсан билээ?

Галсандаш: Мандир унзад л залдаг байсан, ядам сахиусны унзад.

Гантулга: Аан ядам сахиусны унзад?

Галсандаш: Тийм, тэр л залдаг байсан.

Гантулга: Мандир унзад аа?

Галсандаш: Мандир.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Сорынх нь чимэг ямар байсан гэлээ?

Галсандаш: Янз болгоны л юмыг... одоо хонины гэдсийг хээ оруулж, хээ оруулж туламлачихаад л нэг их ороосон юм л байдаг байсан, сор оо. Тэгээд л янзын хор гээд л гадуур нь олон юм байдаг байсан.

Гантулга: Арвайгаар хийх үү?

Галсандаш: Тэгнэ. Арвайгаар хийнэ.

Гантулга: Богд ламын дүйчэн өдрөөр ямар ном хурдаг байсан бэ?

Галсандаш: Мэдэхгүй ээ.

Гантулга: Хайлан хийдэг байсан гэсэн, тиймээ?

Галсандаш: Суудаг байлгүй.

Гантулга: Дан гэлэн үлсүүд суух үү, одоо өөр ламууд суух үү? Гэцэл гэлэнгүүд суух үү?

Галсандаш: Тэр хамаагүй ээ.

Гантулга: Гэлэн нь олон талдаа, гэлэнгийнх нь тоо их талдаа?

Галсандаш: Тийм, гэлэн гэцэл нь олон.

Гантулга: Нүгнээ хурдаг байсан үү?

Галсандаш: Нүгнээ сахидаг.

Гантулга: Нүгнээ сахина гэхээр яадаг байсан юм, та нэг ярь даа?

Галсандаш: Хорин дөрвөн цаг л, хөдөлсөн хойно нь хорин дөрвөн цаг юм уншихгүй, юм дуугарахгүй, юм хуулж бичихгүй...

Гантулга: Тэгж?

Галсандаш: Тэгээд дотроо номоо уншаад л ...

Гантулга: Ямар ном ?

Галсандаш: Хэлж мэдэхгүй. Манай эцэг нэг дагуулж явж айлд нүгнээ сахиж байсан юм. Тэгдэг л юм байсан юм.

Гантулга: Тэр нь ер нь цаад учир нь? Нүгнээ сахидгийн цаад учир нь?

Галсандаш: Ямар учраас үү?

Гантулга: Тийм.

Галсандаш: Тэр яахав дээ, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд санаж бодсон зүйлээ... Идэж уухгүй, тэгээд ярьж хөөрөхгүй хорин дөрвөн цаг түүс юм ярихгүй. Тийм л байна.

Гантулга: Тэгээд л сууж байна?

Галсандаш: Тэгээд л сууж байна.

Гантулга: Одоо энэ дуган шинээр бариад аравнайлах ч юмуу суварга тэр үеэрг овоо тахих ч юмүү тийм том баяр одоо зан үйлээр бол том наадам хийдэг байсан үү?

Галсандаш: Наадам...

Гантулга: Тийм, морь уралдаж, бөх барилдаж?

Галсандаш: Тийм юм хийнэ ээ.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Ямар үеэр хийх вэ?

Галсандаш: Тэр чинь нэг зуны алтан даллага авна гэж...

Гантулга: Алтан даллага аа?

Галсандаш: Тийм, алтан даллага авна гэж...

Гантулга: Тэр нь яадаг байсан юм ?

Галсандаш: Тэр даллага л авдаг юм байна .

Гантулга: Тэр хийд орноороо?

Галсандаш: Тийм. Тэгээд л алтан даллага авна гээд л даллага аваад л морь уралдаж, бөх барилдаад л ...

Гантулга: Бүх лам нар хурах уу?

Галсандаш: Өө тэгэлгүй яахав. Бүх лам хурна. Тэгээд бөхөө барилдуулаад л, морио уралдуулна.

Гантулга: Хаана, хийд дээрээ бөхөө барилдуулах уу?

Галсандаш: Тийм , хийд дээрээ.

Гантулга: Лам нар нь барилдчих уу?

Галсандаш: Тэгнэ. Зүгээр лам нар барилдаад л , бөх барилддаг бол...

Гантулга: Морь?

Галсандаш: Морь уралдана , бөх барилдана.

Гантулга: Та энэ цогчин уншлагаа үзчихээд дараагаар нь ер нь Чойр үзсэн үү, зурхай үзсэн үү , юм үзсэн үү, тэрийгээ жаахан дэлгэрүүлээд?

Галсандаш: Чойр үзсэн.

Гантулга: Чойрын дацанд?

Галсандаш: Тийм. хурлаа, уншлагаа дуусгачихаад тэгээд Чойрт ороод...Тэгээд Чойрын ном үзэж байгаад тэгээд шажинтив ороод тэгээд тарсан даа. Анхандаа зургаан настай сахил аваад, тэгээд аравтын сахил гэж аваад, тэгээд дараа нь гэцэл сахил гэж аваад тэгээд гэлэн болоогүй байж байгаад тэгээд шажинтив ороод гэлэн болж чадаагүй тэгээд л тарсан.

Гантулга: Сахил хүртэхэд чинь нэр өгнө биз?

Галсандаш: өгөлгүй яахав.

Гантулга: Тэр нэрүүдээ хэлвэл?

Галсандаш: Миний нэр Дамдин гэж байсан юм , анхан.

Гантулга: Дамдин?

Галсандаш: Дамдин. Тэгээд гэцэл сахил аваад Галсандаш гэдэг нэр авсан.

Гантулга: Таны уулын нэр чинь?

Галсандаш: Уулын нэр чинь Дамдин гэж байсан юм.

Гантулга: Эцэг эхээсээ өгсөн нэр үү?

Галсандаш: Тийм.Тэгээд гэцэл сахил аваад Галсандаш...

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ Овоотын хурал дээр Цогчин дуган гэж байсан юм байна ш дээ. Тэгээд тэрний өдөр тутмын ямар уншлагатай байсан юм бол?

Галсандаш: Тэр цогчин чинь ямар хурал хурна...

Гантулга: Тэр сүм хийдийг одоо ямар материалаар барьсан байсан юм бол?

Галсандаш: Зөн.

Гантулга: Зөнгөөр үү, хөх зөнгөөр?

Галсандаш: Тийм, хөх зөнгөөр

Гантулга: Бааран дээвэртэй байсан уу, зөн?

Галсандаш: Зөн.

Гантулга: Зөн дээвэртэй байсан уу? Тэр суварга?

Галсандаш: Модон дээвэртэй байсан.

Гантулга: Ганжир энэ тэр нь алтадсан байсан уу, жантан ганжир энэ тэр нь?

Галсандаш: Аа нэг л бүрмэл, шармал юм уу нэг л шар юм л байдаг байсан .

Гантулга: Та ямар дацанд нь сууж байсан, Чойр үзэж байсан, Чойрын дацанд уу?

Галсандаш: Тийм.

Гантулга: Тэр Чойрын дацангийн өдөр тутмын уншлага гэж байна уу? Чойрын дацан тусгайдаа?

Галсандаш: Байхгүй ээ.

Гантулга: Тэр цогчин дуганаасаа тусгайдаа?

Галсандаш: Тийм юм байдаггүй .

Гантулга: Байдаггүй байсан уу?

Гантулга: Жил сарын тийм тусгай уншлага гэж байх уу, тэр Чойрдоо?

Галсадаш: Цогчинд л байдаг байсан, Чойрд байгаагүй байх.

Гантулга: Өөр одоо энэ Чойрын хийдийн зан үйл, дом барина энэ тэр гээд, домын дамжаа барих энэ ёслолууд зан үйлийн талаар? Домоос гадна өөр одоо аграмба барихдаа яадаг байсан, гавжийн дамжаа барьдаг байсан уу?

Галсандаш: Үгүй ээ, гавж болоогүй.

Гантулга: Домын дамжаа л барина?

Галсандаш: Домын дамжаа л барина.

Гантулга: Тэгээд л янх дом эд нар хурах байх даа?

Галсандаш: Янх дом хүрж байсан . Есөн цагаан морьтой...

Гантулга: Тэгээд тэр яадаг байсан, есөн цагаан морьтой?

Галсандаш: Есөн цагаан морьтой хуралдаа л явдаг байсан, Өвөр задгай руу.

Гантулга: Аан Өвөр задгайн тийшээ очиж хурдаг байсан юм уу?

Галсандаш: Тийм.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Тэр нь одоо хэдэн хоног байх уу, өдөртөө л...?

Галсандаш: Өдөртөө л дуусчихна.

Гантулга: Дом ер нь хэд хоног болдог байсан юм?

Галсандаш: Дом уу?

Гантулга: Тийм, дом барих?

Галсандаш: Дом хуруулахад бол...

Гантулга: Тэр дамжаа барихад?

Галсандаш: Нэг өдрийн л , нэг өдөртөө л барина.

Гантулга: Энэ Овоотын хурал бол гавж энэ тэр болж байсан уу?

Галсандаш: Байгаагүй. Дээд хурал бол байсан, гавж болдог.

Гантулга: Байшинтын хурлыг дээд хурал гэж нэрлэдэг?

Галсандаш: Тийм , хоёр байгаа юм дээд хурал чинь. Хоёр хийд байсан.

Гантулга: Ойрхон байсан юм уу?

Галсандаш: Мэдэхгүй, би үзээгүй.

Гантулга: Байшинт гэдэг чинь дээд хурлаа хэлээд байна уу, Байшинтаасаа гадна тусдаа байна уу?

Галсандаш: Тийм, хоёр тусдаа байсан.

Гантулга: Энэ Балдан засгийн хошууны хошуу хурал гэж байсан л байх даа?

Галсандаш: Байсан л байх.

Гантулга: Тэр нь хаагуураа байсан бол?

Галсандаш: Мэдэхгүй.Хошуу хийд гэж...

Гантулга: Энэ дуганууд нь дөрвөлжин дуган байсан уу?

Галсандаш: Дөрвөлжин.

Гантулга: Суварга нь дөрвөлжин суварга байсан уу?

Галсандаш: Үгүй ээ, бөөрөнхий суварга байсан.

Гантулга: Хийсэн материал нь бол энэ хөх зөн тоосго, шавар...?

Галсандаш: Тэгэлгүй.

Гантулга: Түүхий, тэгээд гадуур нь шохойдоод?

Галсандаш: Гадуур нь шохойдоод...

Гантулга: Цагаан тийм өнгөтэй?

Галсандаш:Тийм.

Гантулга: Тэгээд дээд талын дээвэр нь бол бааран байсан уу, мод...?

Галсандаш: Мэдэхгүй ээ, юу байсан юм . Бүү мэд.

Гантулга: Одоо мэдэхгүй байна уу?

Галсандаш: Мэдэхгүй. Суварга л байсан.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга: Энэ домын дамжа барьдаг байсан гэж байна. Тэгээд энэ аграмбын дамжаа , маарамбын дамжаа, зиирэмбийн дамжаа байсан уу? Овоот дээр?

Галсандаш: Мэдэхгүй.

Гантулга:Тэрийг нь одоо мэдэхгүй байна уу, та?

Галсандаш: Мэдэхгүй. Домын дамжаа л байсан, гавж болох хоёрыг л мэднэ.Өөр дамжаа байсныг нь мэдэхгүй.

Гантулга: Нэг дамжаа барихад хэдий орчим лам нар барьдаг байсан бэ?

Галсандаш: Тэр тоо байхгүй. Хэд л бол хэд, тогтсон байхгүй.

Гантулга: Жилдээ дамжаа чинь нэг болох уу?

Галсандаш: Хэд ч хамаагүй.

Гантулга: Ямар иххатай газар байсан бэ?Энэ Чойрын дацан, Сэр ихчаа ламын номыг үздэг байсан уу, Гүнчин жамъян шидав номыг үздэг байсан уу?

Галсандаш: Үгүй, мэдэхгүй.

Гантулга: Энэ сүм хийдүүд нь гадаад оронтой харилцаа холбоотой байсан уу?

Галсандаш: Хятадтай холбоотой.

Гантулга: Аа Төвдтэй холбоотой байсан уу?

Галсандаш: Байлгүй

Гантулга: Сүм хийдийн санхүүжилт, одоо тэр жас нь хаанаас бүрдэж байсан бэ?

Галсандаш: Тэр энэ хаанаас ч юу байхав...

Гантулга: Нутаг орноосоо юу?

Галсандаш: Нутаг орноосоо, хаанаас ч бүрдэх юу байхав. Жас л гээд их л юм бэлдсэн юм л байдаг. Хаанаас бэлддэгийг нь мэддэггүй.

Гантулга: Лам хуваргын нь суудаг байсан орон сууц гэр нь одоо юунд суудаг байсан бэ?

Галсандаш: Байшинд ч сууна, гэрт ч сууна. Аль аль нь .

Гантулга: Энэ хурлын ойролцоо өөр одоо зоч юмуу хандмаа, өөр хурлууд байсан уу?

Галсандаш: Байгаагүй.

Гантулга: Одоо энэ Овоотын сүм хийдийн сүсэгтнүүдийн тухай ?

Галсандаш: Байна аа, ороочин гээд.

Гантулга: Тэд нар байнга ирж байсан уу?

Галсандаш: Тийм, ороочин гээд одоогоор бол ядуучуул.

Гантулга: Аан за за.

Галсандаш: Тийм улсууд зөндөө байна.

Гантулга: Сүм хийд хаагдсан талаар та яриач?

Галсандаш: Хаагдсан талаар уу?

Гантулга: Хэдэн онд ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Галсандаш: Ай мэдэхгүй. Хэдэн онд юм бол...

Гантулга: Нэг нүүсэн гэж та ярьж байсан. Тэгээд л хаагдсан уу?

Галсандаш: Тийм. Нүүлгээд нэг Ханын ар Хүрэн ар гэдэг газар байж байгаад тэндээс гэрүүдээ нүүлгэж байж байгаад , тэгээд...

Гантулга: Хэр үдсэн бэ?

Галсандаш: Нэг сар, хоёр сар гаруй , тэгээд л тарсан.Тэгээд л орон гэр , тэр бурхан номынхоо ажлыг аваачиж чадахыг нь аваачаад л , бусдыг нь хаяад. Тэгээд л Ханын ар Хүрэн толгойтод хоёр сар болоод л тэгээд л тараад бутраад алга болсон.

Гантулга: Та нэг, нөгөө хүүхдийг утсаар ингээд тоглоод байхаар нь нэг настай өвгөн юу гэж хэлж байсан гэлээ?Тэр үүх түүхээс, утсаар нэг ингээд тоглодог байсан гэсэн ш дээ, янз бүрийн дуган сүм хийдэг гэл үү?

Галсандаш: Аан тэр үү, манай эцэг л өнгө өнгийн утсаар дуган сүм бариад , хийдээс хол очиж хөдөө газар,Овоотын шавь нар л дуган сүм бариад ...Манай эцэг л шажиндив орох нь л гэж тэгж байсан юм. Тэгээд л удахгүй шажиндив ороод л ...

Гантулга: Сүм хийд хаагдах үед та ямар ажил хийж байсан бэ?

Галсандаш: Тэрний дараа юу?

Гантулга: Тийм, сүүлд нь?

Галсандаш: Сүүлд нь...

Гантулга: Мал маллах уу?

Галсандаш: Мал маллаж байсан.

Гантулга: Жин хийж байсан гэл үү?

Галсандаш: Тийм, мал маллан, жин хийж байсан. Мал маллахын хажуугаар жин хийгээд л ...

Гантулга: Энэ сүм хийд тарсны дараа байшин барилга нь байж л байсан байх даа. Нэг хэсэг бол, бүр нураагаад хаячихсан юм уу?

Галсандаш: Бүр нураагаад хаячихсан.Энэ нураагаад , дор нь сүйтгээд хаячихсан.

Гантулга: Дор нь сүйтгэчихсэн үү?

Галсандаш: Дор нь сүйтгэчихсэн.

Гантулга: Байшин савыг нь ашиглаад сүм багийн төв гээд ашиглаж барьсан юм байхгүй юу?

Галсандаш: Байхгүй .

Гантулга: Дотор нь үйлдвэр байгуулаад артел , мартел ажиллаж байсан юм байхгүй юу?

Галсандаш: Байхгүй.

Гантулга: Лам нарыг нь ихэнхийг нь баривчлаад яасан гэж байгаа биз?

Галсандаш: Тэгсэн. Лам нарыг ер нь бараг барьсан шүү.

Гантулга: Тэгээд ерөөсөө цаазлаад...?

Галсандаш:Цөөхөн лам нар үлдсэн.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гантулга:Зарим нь уршаа гарсан улс байна уу, хил даваад зугтаад?

Галсандаш: Зугтаж гарсан хүн байхгүй. Юм дуулдаагүй шүү, манай энд...

Гантулга: Та гэцэл сахилаа ямар хүнээс авсан бэ?

Галсандаш: Аан?

Гантулга: Гэцэл сахил аа?

Галсандаш: Манай эцэг...

Гантулга: За за баярлалаа. Овоотын хийдийн тухай ярилцлага өгсөнд баярлалаа.

Галсандаш: За